

ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН 2024 ОНЫ ОНЦЛОХ АЖИЛ

2024.12.27

“ӨВ СОЁЛ МИНУ НЭГДСЭН ӨДӨРЛӨГ” арга хэмжээ

Сумын нийт СББӨ-ыг өвлөн уламжлагч, арга урлал эрхлэгчдийн нэгдсэн өдөрлөг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 250 гаруй иргэн хамрагдсан байна. Өдөрлөгийн үеэр 13 иргэний 8 нэр төрлийн гар урлалын үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж 1,628,000 төгрөгийн худалдан борлуулалт хийгдэж, 5 төрөлд шилдэг бүтээлийг шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Мөн СББӨ-ыг өвлөн уламжлагчдын нэгдсэн тоглолтыг зохион байгуулж нийт 25 өвлөн уламжлагчид “СББӨ-ыг өвлөн уламжлагч” батламж гардуулан иргэд олон нийтэд алдаршуулан танилцуулсан.



“СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”-тэй хамтран ажиллалаа

Соёлын өвийн үндэсний төвийн мэргэжилтэн нартай хамтран Сангийндалай хийдийн зураг зүйн мэдээллийг шинэчлэн биотехнологи, эрсдэлийн судалгаа шинжилгээг мэргэжлийн багаж хэрэгслээр авч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөгөө зөвлөмжийг авлаа.

“МОНГОЛ ГЭР” үзэсгэлэнд оролцлоо

ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн монгол гэрийг хүүхэд залууст болоод дэлхийд сурталчлан таниулах зорилгоор 21 аймгийн онцлогийг харуулсан “Монгол гэр” үзэсгэлэнг Д.Сүхбаатарын талбайд 7 хоногийн хугацаанд зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд манай ОНСТ-ын 5 нэр төрлийн үзмэр дэглэгдэн байршиж, соёлын өвийн ажилтан Б.Мягмарсүрэн гэр үзэсгэлэнд ажиллаж туршлага солилцлоо.



ОНСТ-ын үзмэрийг үндсэн хөрөнгөд бүртгэн авлаа

Соёлын төвийн дэргэдэх ОНСТ-ын 186 дэсийн 439 ширхэг үзмэрийн үнийг аймгийн музейн захирал Б.Баярмаагийн зөвлөгөө, соёлын яамнаас гаргасан жишиг үнийн мэдээлэлтэй харьцуулан дахин үнэлгээг хийж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн нийт 33,326,000 төгрөгийн үнэ бүхий дурсгалт зүйлийг үндсэн хөрөнгөд бүртгэж авлаа.

ЭРДЭНЭДАЛАЙ СУМ БАЙГУУЛАГДСАНЫ ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙН дурсгалуудыг хүлээн авлаа.

Эрдэнэдалай сум байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баяр наадмын хурдан морины медалийн загвар, 100 жилийн ойн медаль, үнэмлэх, алтан гадас одонгийн батламж, баяр наадмын дүрс бичлэг, 100 жилийн ойн ном, аяга зэргийг музейд хадгалууллаа.

